



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/378

Чингис хот

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл
олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 30 дугаар зүйлийн 30.1.3, 30.1.6, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4 дэх заалтыг тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боловсрол, соёл, урлагийн газрын дүгнэлтийг үндэслэн Хэрлэн сумын төрийн өмчийн 10 дугаар цэцэрлэгт сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай

2. Сургалтын үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу чанар хүртээмжтэй зохион байгуулахыг Хэрлэн сумын 10 дугаар цэцэрлэгийн үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Мөнгөнтуяа/-д, удирдлага зохион байгуулалт, арга зүйгээр хангаж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газрын дарга /С.Мөнхцэцэг/-д тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ